



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/716

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" XXV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хутаг-Өндөр сумын Хантайн 2 дугаар багт "Хяналтын пост барих" ажилд 20,000,000 (хорин сая) төгрөгийн гэрээ байгуулах эрхийг Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа (М.Оюунбат)-д олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг иргэн (Б.Даваахүү), чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, холбогдох баримт материал бүрдүүлэн тайлагнаж ажиллахыг Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга (М.Оюунбат) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардлагатай хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний "Хяналтын пост барих" төсөл арга хэмжээний зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ